

## Хэл, Соёлын харьцаа хамаарлын асуудалд

Ж.Баянсан (МУИС)

Ухамсар, хийсвэрлэн сэтгэхүй, хэлний чадвараараа хүн, амьтнаас онцгой ялгаатай гэж үздэг баталгаа шаардахгүй үнэн бий. Тэгвэл хүн төрөлхтөн нийгэмшлийнхээ болхи бүдүүлэг, хамгийн энгийн үе шатаасаа эхлүүлээд өдгөө хүртэл бие эрхтэнээрээ үйлдэх рефлексийн ба рефлексийн бус үйлдэлтэйгээ дээрх онцгой чадваруудыг хослуулан нэгэн цогц үйл ажиллагаанд орчилдуулж, улам улмаар боловсронгуй болгож ирснийхээ ачаар соёлын зүйлийг бүтээж, соёлт хүн төрөлхтөн төлөвшиж ирсэн нь маргаангүй биз ээ. Тэгэхлээр хүнээс ангид соёл, соёлоос ангид хүн гэж байх боломжгүй байна. Иймээс соёл бол хүн төрөлхтөний оршихуйн нэг үндэс, оршихуйн нэг арга нь болдог гэж хэлж болох юм. Ийм ч учраас соёлын тухай судлаачдын 600 гаруй тодорхойлолт байдаг гэсэн мэдээ бий. Тэгвэл "хүнд байдаг <хүнлиг юм> болгоныг соёл хэмээх концептэд төвлөрүүлж, харин хүний байгалаас ялгарч онцгойрсон шинж, түүний өөрчлөн бүтээх хийгээд хууль тогтоох үйл ажиллагааг соёл иргэншил хэмээх концептэд төвлөрүүлэн, соёлын үзэгдэл (феномен)-ийн баримтажсан илрэл болгоныг соёл иргэншил (цивилизация) гэж болох юм (Телия 1996:223) гэсэн тодорхойлолт бидний энд авч үзэх асуудалд илүү ойр санагдаж байна.

Хийсвэрлэн сэтгэх чадвар нь хэлтэй болохын угтал байсан гэж одоо хэдийгээр тодорхойлдог болсон нь хэлийг хүн төрөлхтөний соёлын нэг хэсэг, соёлын нэг зүйл хэмээн үзэхтэй огтхон ч харшлахгүй юм.

Харин соёл бол хүний бие эрхтэний болон оюун ухааны бүхий л чадвар боломж, чанар шинжийг удамшлын бус аргаар нэг хүнээс нөгөө хүнд буюу үеэс үед уламжлан дамжуулж байдаг хэрэглүүр ажээ.

Соёлын зүйлийг бүтээж бий болгох арга, илрэх хэлбэр, агуулгаар нь эдийн соёл, оюуны соёл гэж ерөнхийд нь хоёр зүйл болгон хэлэлцдэг. Биет зүйлээр илэрч байгаа нь эдийн соёлын зүйл, ухамсарлал, оюун ухааны үйл ажиллагаагаар бий болдгий нь оюуны соёл гэж үздэг.

Ингэхлээр эдийн ч бай, оюуны ч бай соёлын зүйл болгон нь тэмдэг-дохионы шинжтэй байхаас гарцаагүй байна.

Хүн төрөлхтөний хэрэглэсээр ирсэн элдэв зүйлийн тэмдгийн тогтолцооны дотроос хамгийн төгс төгөлдөр нь даруй хэлний тогтолцоот тэмдэг гэдэг нь маргашгүй билээ. Тэгвэл соёлын нэг зүйл болсон хэлний тэмдэг соёлын зүйлстэйгээ эргээд ямар харьцаа хамааралтай байдаг хийгээд хэлний тэмдгээр соёлыг хэрхэн нэвтрүүлж илэрхийлэх, үеэс үед өвлүүлэн уламжлуулах тухай асуудал зайлшгүй сонирхол татдаг байна.

Хүн хэдийгээр биологийн амьтан болж төрдөг ч гэсэн тодорхой нийгэмд амьдарч аж төрөх нь зайлшгүй учраас өмнөх үеийнхний бүтээн бий болгосон соёлын зүйлтэй харьцаж, түүнийг ашиглаж хэрэглэхэд тулгарна. Энэ бол тэдгээрийн амьдрах хэрэгцээнийх нь зайлшгүй нөхцөл болно.

Ийнхүү соёлын зүйлтэй харьцаж, улмаар түүнийг өөрийнхөө хэрэгцээг хангах зорилгоор ашиглахдаа гагцхүү уг зүйлийн зориулалтаас ангид түүнийг ашиглаж хэрэглэх боломжгүй болтлоо хэвшин зуршдаг байна.

Өөрөөр хэлбэл, аяга, халбага, хувин, тогоо зэрэг нь ямар ч хэлбэр, хэмжээтэй, ямар ч материалаар хийсэн байлаа ч гэсэн хэрэв түүнд шингэн юм агуулах болвол амсры нь доошоо харуулж ашиглах боломжтой байхууцаар хүний үйл ажиллагааны хэв маяг хэвшин төлөвших учиргүй гэсэн үг юм.

Гэвч халбагыг тогоо болгох ч юмуу, хувинг халбага болгоно гэж ойлгож болохгүй нь мэдээж. Хоол ундны эдгээр хэрэглүүр тус бүрдээ өөр өөр зориулалт үүрэгтэй, тэр л зориулалт үүргээр нь ашиглаж хэрэглэх нь бас мэдээж юм.

Түүнчилэн юмыг тасалж огтлохдоо хутга, хөрөөг ирээр нь үйлдэх болохоос биш мөрөөр нь хийдэггүй. Хэрэв түүнийг мөрөөр нь ч юмуу, эсвэл шал өөр ямар нэг ирмэгтэй зүйлээр тухайн юмыг таслах тохиолдол байвал уг зэвсгээр хийх зөвхөн аргы нь ашиглаж байгаагаас өөр зүйл биш юм.

Энэ бол соёлын зүйлтэй харьцах, түүнийг ашиглаж хэрэглэх, бас түүний бүтцийн загвар, түүнийг бүтээх үйл ажиллагааны загварт тулгуурлан түүнтэй ижил зүйлийг давтан бүтээх буюу хувилах эсвэл түүнтэй хэлбэр, агуулгын аль нэг шинжээрээ адилсуу өөр шинэ зүйлийг хийж бүтээх чадварыг эзэмших арга үндэс болно.

Ингэхлээр соёлын аливаа зүйлийг ашиглаж хэрэглэх аргыг хүүхдэд гэхэд л бүр нялх багаас нь зааж, хэрэглүүлж, хэрэгжүүлж, хэвшил зуршил болгодог. Үйл ажиллагааны энэ хэвшил зуршил нь хүний тархинд тэр л янзаараа нэг зүйлийн дүрслиг хэв загвар байдлаар хоногшино.

Хүн, соёл хоёрын харьцааны онцлогийг амьтны удамшлын зүй тогтолтой холбож Е.Ф. Тарасовын (1999) дэвшүүлсэн санаа ихээхэн сонирхолтой байна. Түүнээс ишилбэл:

Культура как в филогенезе, так и в онтогенезе человека играет роль генетической программы, позволяя ему прижизненно самостоятельно, и в известной мере ориентируясь на собственной воле, формировать способности, которыми обладали люди предыдущих поколений, создавшие эту культуру, ставшую для их потомков аналогом генетической программы.

Гэвч соёлын зүйлс нь хүний чадварыг биежмэл хэлбэрээр удамшлын бус аргаар үеэс үед өвлөн уламжлуулж байгаагаараа онцлог юм. Харин үйл ажиллагааных нь хэв загвар болтлоо хүнийг насан турш нь дагаж, хойч үед нь нэвтрэн уламжилж байдгаараа удамшлын программтай адилсуу зүй тогтолтой болж байна.

Хүн соёлын зүйлтэй харьцана гэдэг бол уг юмыг байгаа тэр чигээр нь ерийн тусгах хэрэг огтхон ч биш, харин түүнийг бүтэц махбодоор нь "задалж" (энэ нь Тарасовынхоор "распредмечивание" болно), хэрэгцээгээ хангах зорилгынхоо хэрэглүүр болгон ашиглах боломжийг эрэлхийлж эхэлнэ. Тоглоом наадгай зэрэг сонирхлы нь татах эд юм болгоныг, бяцхан хүүхэд анхандаа, чадах хэрээрээ хэдэн хэсэг болгон салгаж "эвдэлчихээд" байдаг. Тэгснээ салгасан юмаа буцаагаад эвд нь оруулж, угсарч сурдаг. Ингэхлээр бага насны хүүхдэд зориулсан задалж угсрах зохиомжтой тоглоом наадгай түгээмэл байдаг нь учиртай зүйл ажээ [Баянсан 2000:39].

Бяцхан хүүхдийн тоглоом наадгайтайгаа харьцах энэ шинж, насанд хүрсэн хүн соёлын элдэв зүйл, ялангуяа нарийн бүтэц зохиомж бүхий техникийн эд ангитай харьцаж, түүний учир оньсыг тайлахыг оролдож буй үйл ажиллагааны хэв маяг хоёр нь сэтгэц, танин мэдэхүйн нэг төрлийн үзэгдэл, нэг төрлийн үйл ажиллагааны арга, хэв маяг гэж үзүүштэй байгаа юм.

Өөрөөр хэлбэл, хүн, соёлын зүйлтэй харьцаж эхлэхийн цагт тухайн юм "юу байна вэ?" нь төдий л чухал биш, харин "яагаад ийм байна вэ?" гэдэг хандлага чухал учир холбогдолтой болдог байна.

Тодруулбал, соёлын зүйл болгоныг ийн бүтэц махбодоор нь задлахын хэрээр түүний хэлбэр маяг, бүтэц байгууламжтай нийцсэн үйлдэл, үйл ажиллагааны хэв маяг буюу чадвар хүний бие цогцост аяндаа төлөвшин тогтдог байна. Ийм чадварыг эзэмших арга хэлбэр нь эсвэл өөрийн зоргоор, "аяндаа" бий болох, үгүй бол зориуд, албадмал аргаар төлөвшүүлэх байдалтай байж болно. Иймэрхүү үйл ажиллагааны онцлог нь тухайн соёлын зүйлийн субстанцийн хэв загвар, хэлбэрт нийцсэн үйлдэл, үйл ажиллагаа хийхэд хүрнэ гэсэн үг юм. Энэ чадвар нь тухайн зүйлийн хэлбэр бүтэц, түүнтэй харьцах үйл ажиллагааны тогтвортой хэв маяг (stereotype) байдлаар сэтгэцэд хадгалагдана. Сэтгэцийн энэ тогтвортой хэв шинж нь соёлын тухайн зүйлийг ашиглаж хэрэглэх, бүтээж бий болгох, улмаар түүнийг үеэс үед өвлүүлэн уламжлуулах (translation) оньс болдог байна.

"Усы нь уувал ёсы нь дага", "Сохрын газар сохроор, доголлонгийн газар доголлонгоор яв, Сохрын газар нүдээ ань, доголлонгийн газар хөлөө өргө" гэдэг зүйр үгийн цаад утга санаа нь өөр ахуй орчин, өөр ёс

заншил, өөр соёл, өөр соёл иргэншилтэй газар түүнд дасан зохицож амьдрахаас өөр аргагүй болох учраас тэдний соёлын дэг ёсны зарим арга хэлбэрийг өөртөө албадмалаар, зориуд төлөвшүүлж авах ёстойг өгүүлсэн байна.

Харийн соёл байтугай нэг соёлын хүрээний доторх нийгмийн хэсэг бүлгийн нийгэмшлийн онцлогоос шалтгаалж, соёлын хэв маяг, төлөвшилт ялгаатай байх учиртайг "Газар газрын зан, гүзээ гүзээний булан өөр, Жалга жалгын нохойны хуцах өөр, лам ламын уншлага өөр" гэх мэтийн хэллэгээр илэрхийлсэн байдаг.

Энэ баримтыг өөрийгөө бусадтай ижилтгэх, бусдыг өөртэйгээ ижилтгэх (identification, self-identification) үзэгдэлтэй холбон тайлбарлах боломжтой байгаа юм. Өөрөөр хэлбэл, нийтлэг, бодгаль хоёрын харьцаа хамаарал буюу бодгалиас нийтлэгт нэгдэж нийлэх, нийтлэгээс бодгаль шинжээрээ онцгойрч ялгарах зүй тогтлын үүднээс эдгээр хэллэгүүдийн утга санааг авч үзэх ёстой болно.

Соёлын аливаа зүйлийг уламжлуулахад тухайн зүйлээс гадна түүнийг бүтээж хийсэн үйл ажиллагаа, бас түүний бүтэц хэлбэр, бүтээх үйл ажиллагааны тухай сэтгэцийн хэв загвар гол хүчин зүйл болно. Үүний ачаар соёлын зүйлс удамшлын бус аргаар үеэс үед маш богино хугацаанд хүний чадвар болж төлөвших учиртай байна.

Хүний хэлний чадварын үүрэг хэрэгжих нөхцөл нь дараах зүйлийн мэдлэгийг давын өмнө эзэмших шаардлагатай болно. Үүнд:

- 1) тухайн хэлний үгийн сангийн мэдлэг,
- 2) хэлзүйн дүрмийн тогтолцооны мэдлэг,
- 3) ертөнцийн юм үзэгдэл, тэдгээрийн хоорондын харьцаа хамаарлын тухай ерөнхий мэдлэг байх болно. Үүнээс хэлний үгийн сан, хэлзүйн дүрмийн тогтолцооны тухай мэдлэг нь хэлний илэрхийллийг утгат нэгжээр нь ялгаж задлах, бас түүнийг угсарч холбон өгүүлбэр буюу мэдээлэл үүсгэх, өөрөөр хэлбэл, хэлний аливаа илэрхийллийг өгүүлэгч-сонсогчийн харилцах сэдэл, төрөгдөл санаа, зорилго тэргүүтнийг семантик, синтаксисийн хүрээнд дотоод ба гадаад хэлэхүйн төвшинд төлөвлөн томъёолох, улмаар хэлний тэмдгээр нэвтрүүлж илэрхийлэх хүртэлх хэл-сэтгэцийн олон шатлалт үйл ажиллагаа буюу мэдээллийг хүлээн авах ба бүтээн үүсгэх чадварыг төлөвшүүлдэг.

Хэлэхүйн мэдээллийг үүсгэх аливаа загварын зарчмын үе шатыг А.А.Леонтьев дараах маягаар тодорхойлжээ. Үүнд:

- 1) Этап мотивации высказываний,
- 2) Этап замысла (программы Плана),
- 3) Этап осуществления замысла (реализации Плана),
- 4) Этап сопоставления реализации замысла и с самим замыслом

[1961: 133, 153] гэжээ.

Гэвч хэлний мэдээллийг үүсгэх, хүлээн авч ойлгоход зөвхөн хэлний үгийн сангийн мэдлэг, хэлзүйн дүрмийн мэдлэг хангалттай биш, бас юм

үзэгдэл, тэдгээрийн хоорондын харьцаа хамаарлын тухай "дэвсгэр мэдлэг" ("фоновые знание", энциклопедические знания) [Верещагин 1983] зайлшгүй шаардлагатай болно. Тийм учраас "Тос гүзээлэх гээд тугалаа гүзээлэх" гэсэн хэллэгт орсон 3 үг тус бүрийн шууд нэрлэсэн утга, түүнийг өөр хооронд нь холбож, уг өгүүлбэрийг үүсгэсэн хэлзүйн дүрэм монгол хэлээр харилцаж чаддаг хэн хүнд ойлгомжтой байх авч, зун намрын дэлгэр цагаар үнээ малаа сайн сааж, арвин өрөм тос аваад, улмаар түүнийгээ хонины гүзээнд нягтруулан шахаж, нөөцлөн хадгалдаг арга ажиллагааг наанадаж мэдэх, нөгөөтээгүүр, зөвхөн тос л арвин их хураахад хэт шунахайрч, тугал нь хөхөж тэжээл тэвээрэг авах ёстой сүүг шавхан саагаад байвал эцэстээ тугал нь турж үхэхэд хүрнэ гэдгийг мэдвэл сая дээрх хэллэгийн утга тодорхой болж ирнэ.

Ингэхлээр монгол малчдын нүүдлийн соёл, соёл иргэншлийн нэг зүйл болох цагаан идээг боловсруулж, хэрэглэдэг уламжлалт арга технологийн тухай энэхэн л "дэвсгэр мэдлэг" дутагдвал уг хэллэгийн жинхэнэ утга санааг зөв тайлахад хэцүү болох нь ойлгомжтой байна.

Ингээд хэлний тухай мэдлэг, ертөнцийн тухай энэ "дэвсгэр мэдлэг" нийлээд хүний ухамсрын агуулгыг бүрдүүлж өгдөг. Ухамсрын агуулга нь соёлын зүйлийг эзэмших явцад бүрэлдэж, тухайн соёлын зүйлийн биежмэл хэлбэр ба түүнийг бүтээх, түүнтэй харьцах, улмаар түүнийг ашиглаж хэрэглэх үйл ажиллагааных нь хэлбэртэй хамтаар сэтгэлгээ (mentality)-ний хэлбэр, тогтвортой хэв шинж, "дардас" байдлаар ухамсарт төлөвшин хадгалагддаг байна.

Ийнхүү аливаа шинэ мэдлэг бий болохдоо соёлын зүйлсийг эзэмших явцаар үл барам, хэлж харилцах явцад ухамсарт төлөвшсөн бэлэн дүрийг хэлний мэдээллийг нэвтрүүлж байгаа үг хэллэгтэй, хэлбэр, агуулгаар нь сэргээн авалцуулах аргаар үүсгэдэг байна. Харилцаанд хэрэгжих сэтгэхүй, сэтгэлгээний энэ үйл ажиллагааны арга зарчим нь аж хэрэглэгээний үүднээс авч хэлбэл, хязгаарлашгүй олон зүйлийн мэдлэг бүтээх боломжийг бүрдүүлж өгдөг байна.

Харилцаа бол угаасаа диалог шинжтэй байдаг учраас бусад хүний нэвтрүүлсэн мэдээллийг хүлээн авах явцад шинэ мэдлэг бий болохдоо хэл-сэтгэхүйн үйл ажиллагааны, дээр тэмдэглэсэн, зарчмын үе шатыг туулж, сонсогч-уншигчаас мэдээллийн агуулгыг сэргээн шинэтгэж, хэлбэржүүлэн илэрхийлэх байдлаар хэрэгждэг бол мэдээллийг үүсгэн нэвтрүүлэх явцад хэлний мэдээлэл нь хэлэгч-бичигчийн хувьд шинэ мэдлэгийг хэлбэржүүлэн томъёолох арга хэрэглүүрийн үүрэгтэй байна.

Тодорхой тэмдэг, ялангуяа хэлний тэмдэг-дохиог зууч болгосон харилцааны тохиолдол болгон нь ямагт "шинэ нээлт" ("эвристично" хэмээн А.А.Леонтьев томъёолсон байдаг) байдаг учраас уг тэмдгийг уридаас нэгэнт "бэлэн" байгаагаар нь дахин хэрэглэсэн ч гэсэн заавал шинэ агуулга илэрхийлж, утга санааны шинэтгэл болсон байдаг байна.

Иймд аливаа шинэ мэдлэг үүсэх оньс механизмыг таньж ойлгохын тулд ухамсрын дүр, дүрслиг байдлын хэв маягийг анхаарч үзэх шаардлагатай болно. Орчин үеийн сэтгэлзүйн ухааны тодорхойлолтоор ухамсрын дүр гэдэг нь бодот ертөнцийн тодорхой үзэгдлийн тухай

мэдлэгийн иж бүрдэл ажээ. Тэгвэл ухамсрын энэ дүр нь мэдэрч таних, ухаарч таних гэсэн хоёр хэсэгтэй. Мэдэрч таних нь мэдрэхүйн эрхтэний чадамж, үйлдлээр нөхцөлдсөн, бодгальжсан танилт байдаг бол ухаарч таних нь филогенезийн төвшинд ухагдахуун хэлбэрээр хуримтлуулсныгаа онтогенезийн төвшинд эзэмшсэн мэдлэг, оюун дүгнэлт, концепт болох юм. Гэвч ухаарлын дүр буюу оюунлиг дүр нь сэтгэлзүйн шинжээрээ мэдрэхүйн дүрээсээ өвөрмөц ялгаатай байна гэж үздэг. Юу гэвэл, юмыг ухаарч танин мэдсэний үр дүнд бий болох оюунжсан дүр нь бидний шинээр таньж мэдэхийг эрмэлзэж байгаа юм үзэгдлийн тухай мэдлэгийг өөртөө тээж яваа Хүнтэй харилцах явцад төлөвшдөг байна.

Тэгвэл хүн төрөлхтөний харилцаандаа хэрэглэж ирсэн тэмдэг-дохионуудын дотроос хийсвэр хэрнээ хамгийн боловсронгуй болсон тэмдэг-дохио нь даруй хэлний тэмдэг-дохио байдаг учраас ухамсрын дүрийн оюунлиг шинжийг төлөвшүүлэхэд хэл ямар үүрэг рольтой байдаг вэ? гэдэг асуудал зайлшгүй урган гарах болно. Өөрөөр хэлбэл, энэ асуудал нь эцсийн эцэст, хэлний тэмдэг нь "соёлын тэмдэг"-ийн үүргийг гүйцэтгэх [Телия 1996:214-269] зүй тогтол, онцлогийг нээж гаргах зорилтыг дэвшүүлж, шийдвэрлэнэ гэсэн үг болно.

Дээрх асуултын баримжаа хариулт болгож дараах санааг товчхон тэмдэглэе.

Хэлэхүйн харилцаанд хэлэгч-бичигч, сонсогч-уншигч хэмээх харилцан байр-үүргээ солилцож байдаг, наад зах нь хоёр хүн оролцоно. Үүнийг хэрэв соёл, хэлний харилцан хамаарлын парадигмд хамаатуулж үзвэл, хэлэгч нь соёлын зүйлсийн тухай агуулга бүхий хэлэхүйн мэдээллийг сонсогчид хандаж нэвтрүүлнэ. Харин сонсогч нь өөртөө байгаа мэдлэгийн сан хөмрөгөөсөө тухайн мэдээллийн агуулгад нийцэх хэсгийг сонгон авч, хэлэгчийн мэдээллийн агуулгад авалцуулан нийцүүлж, зохион боловсруулна. Үүний үр дүнд үүссэн мэдээлэл нь ерөнхий агуулгаараа хэлэгчийн мэдээлэлтэй ихэнхдээ дүйх боловч, сонсогчийн хувьд уг зүйлийн тухай хуучин мэдлэгээс нь ургаж гарсан, ямар ч гэсэн шинэ мэдлэг байдаг гэж үздэг (дээр "нээлтийн шинжтэй"- "эвристично" гэж ишлэн тэмдэглэснийг саная). Гэвч зарим нөхцөлд тэдгээр мэдээллийн агуулга тохирохоосоо зөрөх нь илүү, заримдаа бүр тэс өөр болох ч боломжтой. Хэрэв тэдгээр мэдээллийн агуулга аль болох адил байвал харилцааны зорилго биелж байна гэж үздэг. Харин үүний эсрэгээр, агуулга нь зөрөхийн хэрээр харилцаа дутуу дулимаг, бүрхэг бүдэг болох, бүр эцэстээ үл ойлголцох байдалд ч хүрч болно. Иймэрхүү үзэгдэл нь наад зах нь хэлний мэдлэг, мэдрэмж, цаашилбал, ертөнцийн юм, үзэгдэл, тэдгээрийн хоорондын харилцаа хамаарлын тухай ерөнхий-дэвсгэр мэдлэг ("фоновые знания", "энциклопедические знания") зэргээс шалтгаалах боловч ялангуяа өөр өөр соёл-хэлтний харилцаанд түгээмэл ажиглагддаг байна. Гэвч сүүлд тэмдэглэсэн энэ баримт бол орон зай, цаг хугацааны орчилын зөвхөн тодорхой нэг бичил оронзай, агшин мөчид хүчин төгөлдөр байдаг, харьцангуй үзэгдэл учраас хэлний тэмдгээр зуучлуулсан соёлын тухай мэдээлэл хүний ухамсард оюунлиг дүр болж үүсэн хадгалагдах сэтгэхүйн үйл ажиллагааны хийсвэрлиг мөн чанартай огтхон ч харшлахгүй гэдгийг тэмдэглэх хэрэгтэй юм.

Ялангуяа нийгэмшсэн нэгэн бодгаль амьдралынхаа туршид өөрт нь зайлшгүй харьцаа хамааралтай байж болох юм үзэгдэл болгоныг "задалж", "угсрах" боломжгүй учраас энэ дутмагшлы нь нөхөх арга хэрэглүүр нь даруй хэлний илэрхийлэл болно. Хэл бол хүн төрөлхтөний эртнээс эдүгээ хүртэл бүтээн бий болгосон эдийн болон оюуны соёлыг хадгалан нөөшлөх (кумуляция); (чухамдаа бол тэмдэглэх), өвлүүлэн уламжлуулах үүрэгтэй хэрэглүүр хэмээн хэлшинжлэлийн зохиолд түгээмэл дайралддаг тодорхойлолтоос үүтгэж, соёлын зүйлийг нэвтрүүлэх хэлний үүрэг роль, чадвар боломжийн мөн чанар юу байх вэ? гэдэг асуултын хариуг баримжаалбал: Агуулгы нь хэлний тэмдгийн бод биеэр зуучлан нэвтрүүлж, оюунжсан дүр, дүрслэл байдлаар ухамсард тогтоон бэхжүүлж байдаг хүний онцгой чадвар буюу мэдлэг юм гэж үзэх нь зүйд нийцүүштэй байна.

Соёлын зүйлийг өвлүүлэн уламжлуулахад хэлний үүрэг оролцоо ямар байдаг тухай Е.Ф.Тарасовын [1999] дэвшүүлсэн үзэл баримтлал нь бидний энэ судалгааны ажилд чухал учир холбогдолтой байгааг тэмдэглээд түүнээс ишилье:

Необходимо подчеркнуть, что новые знания в речевом общении формируются самим реципиентом и только им, а донор может лишь способствовать этому процессу, предоставляя речевые сообщения и тем самым регулируя этот процесс, но очевидно, что тела языковых знаков ничего не транслируют, а только позволяют донору контролировать процесс производства новых знаний у реципиента...Язык не транслирует культуру, не хранит и не передает никаких знаний – знания и в целом все человеческие сущностные силы могут хранить только сами люди в своем теле, и только они могут организовывать при помощи культурных предметов, образцов общения и языка выработку сущностных человеческих сил у нового поколения членов общества.

Ингэхлээр хэлний илэрхийллийн тусламжаар соёлын зүйлийг үеэс үед уламжлуулахад, үнэндээ, хэлний тэмдгийн бод бие буюу гаргалгын тал нь биш, харин түүний агуулгын тал буюу утга нь чухал учир холбогдолтой ажээ. Харин хэлний тэмдгийн бод бие нь харилцагчдын ухамсар, оюун санаанд байгаа соёлын зүйлийн тухай мэдлэгийг "цочроож" сэргээдэг, зуучийн л үүрэгтэй гэж хэлж болох юм. Ийм учраас ямар нэг үндэстэн угсаатны уламжлалт соёлын агуулгыг илэрхийлсэн өвөрмөц хэллэг зэрэг тогтвортой хэллэг, заримдаа соёлын зүйлийг энгийн тодорхойлсон өгүүлэмжид орсон үг тус бүрийн дангаар байхдаа нэрлэж илэрхийлдэг утга, тэдгээрийн хэлзүйн холбоо харьцааг мэдээд, бас уг илэрхийллийн ерөнхий агуулгыг шууд утгаар нь баримжаалаад байгаа хэрнээ уг хэллэгийн гүн бүтцэнд илэрсэн жинхэнэ утга санаа нь чухам юу болохыг харь соёлтон байтугай, төрөлх соёл-хэлтэн ч ухаж тайлбарлахад төвөгтэй байдгийн учир үүнд оршино.

### Ишилсэн бүтээлийн нэр

- Баянсан Ж. *Соёл, Хэл, Үндэстий сэтгэлгээ*. Улаанбаатар. 2002  
Верешагин Е.М, Костомаров В.Г. *Язык и культура*. Москва. 1983  
Леонтьев А.А. *Психоллингвистика*. Москва.1961  
Тарасов Е.Ф. *Язык как средство трансляции культуры*.  
-*Фразеология в контексте культуры*. Москва.1999  
Телия В.Н. *Русская фразеология*. Москва.1996